



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/119

Булган сум

Эрх шилжүүлж, ажил гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны X Хуралдааны XII/21 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах төсөл, арга хэмжээний зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах эрхийг Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (М.Оюунбат), Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (Д.Болорчулуун) нарт даалгасугай.

3.Хавсралтад тусгагдсан арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, тайлагнахыг Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга (М.Оюунбат), Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга (Д.Болорчулуун) нарт нарт тус тус үүрэг болгосугай.

4.Дээрх 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх зардлын Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

5.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Сугаг Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6323010065

Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр,  
сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах  
төсөл арга хэмжээ

| Д/д | Ажлын нэр төрөл   | Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/ | Хугацаа        | Эрх шилжүүлсэн тусгай хамгаалалттай газар нутгийн нэр                                     |
|-----|---|-----------------------------------|----------------|---|
| 1   | 2   | 3                                 | 4              | 5   |
| 1   | Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах  | 15,000.0                          | 2023 он        | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 1.1 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн танилцуулга болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, гарын авлага, тараах материалыг боловсруулж, хэвлүүлэн олон нийтэд сурталчлах                 | 1,000.0                           | Улирал бүр     | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 1.2 | Байгаль орчин аялал жуулчлалын газартай хамтран "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд бүсчилсэн сургалт зохион байгуулах  | 2,000.0                           | II улиралд     | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 1.3 | ЕБС-иудын дунд Байгаль орчны тэмдэглэлт баяруудыг тэмдэглэн өнгөрүүлэх, байгаль хамгаалагчдын ажлыг сурталчилсан цуврал нэвтрүүлгийг "Сайхан монгол" телевизтэй хамтран цуврал нэвтрүүлэг бэлтгэн гаргах (4 удаа) | 4,000.0                           | Улирал бүр     | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 1.4 | Аялал жуулчлалын маршрутыг гаргаж, иргэдэд сурталчлан таниулах, аялагчдын тоог гаргах, хог хаягдалгүй аялах зөвлөмж, танилцуулга тараах   | 2,000.0                           | II-III улиралд | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 1.5 | Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журмыг хэрэгжүүлэх, орчны бүс нутагт хяналт тавих   | 4,000.0                           | Улирал бүр     | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |

|     |   |         |                |   |
|-----|---|---------|----------------|---|
| 1.6 | Тусгай хамгаалалттай газрын хамаарал бүхий ЕБС-иудад 1000 цэцэгийн баяр зохион байгуулах  | 2,000.0 | II улиралд     | Зэд Хантай Бүтээлийн нурууны Дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга М.Оюунбат |
| 2   | Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах  | 5,000.0 | 2023           | Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Болорчулуун      |
| 2.1 | ХТБЦГ-т болон орчны бүсэд оршин суугч иргэдэд гарч болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, эрсдэл гарсан үед нийтийн оролцоотой шуурхай хамгаалалтын арга хэмжээ авах арга зүйн зөвлөгөөг нийтэд өгөх   | 1,000.0 | Улирал бүр     | Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Болорчулуун      |
| 2.2 | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн танилцуулга болон байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах, цахим самбар 1-ийг шинээр хийж Элсэн тасархайн тоглох цэгт байршуулах, гарын авлага, тараах материалыг боловсруулж, хэвлүүлэн олон нийтэд түгээн сурталчлах   | 2,000.0 | Улирал бүр     | Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Болорчулуун      |
| 2.3 | ШУА-н Газар зүй, Геоэкологийн хүрээлэн, Булган аймгийн БОАЖГ-тай хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ТХГН-т болон Орчны бүсийн сумдын иргэдэд бүсчилсэн сургалт зохион байгуулах, “Рашаант суманд жишиг ногоон байгууламж” бий болгох   | 1,000.0 | II улиралд     | Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Болорчулуун      |
| 2.4 | Аялал жуулчлалын шинэ маршрутыг Элсэн тасархайгаас Шивэртийн туурь, Ямаатын цохио, Гурвалжин уулын бичээс гэсэн чиглэлээр гаргаж, маршрутын дагуу зам чиглэлийг тэмдэгжүүлж, олон нийтэд цахимаар сурталчлан таниулах, аялагчдын тоог гаргах, аялагчдад хог хаягдалгүй аялах зөвлөмж, танилцуулга тарааж, хатуу хог хаягдлын тархацыг сааруулах | 1,000.0 | II-III улиралд | Хөгнө Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Д.Болорчулуун      |